



БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТ

2024

"Тэнгэр даатгал" ХК-ийн Байгаль Орчин, Нийгэм, Засаглал (БОНЗ)-ын үйл ажиллагааны тайланг тогтвортой хөгжлийн удирдлага, даатгалын салбарын мэдээлэл, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах, сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх, нийгэм, засаглал, иргэдийн даатгал, эрсдэлийн болон эрүүл мэндийн боловсролыг дэмжих төслүүд, түүний хэрэгжилт, зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтөд хувь нэмрээ оруулах гэсэн агуулгын хүрээнд дараах байдлаар дүгнэлт хүргүүлж байгааг хүлээн авна уу. Үүнд:

НЭГ. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН УДИРДЛАГА

Өнөө үед байгууллага болон нийгэм, улс орны үйл ажиллагаа, бизнесийн урт хугацаанд тогтвортой байдлыг хангахын тулд удирдах, төлөвлөх, хэрэгжүүлэх үйл явцаа тогтвортой хөгжлийн удирдлагаар эрхэлдэг болсон билээ. Өөрөөр хэлбэл, эдийн засаг, нийгэм, байгаль орчны гурван үндсэн талын тэнцвэрийг хадгалах чиглүүлэг бүхий НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн Зорилгууд (Sustainable Development Goals - SDGs) зэрэг олон улсын хөтөлбөртэй уялдуулан ажилладаг болоод байна.

ДНБ-д эзлэх даатгалын хураамжийн хувиар хэмжигддэг даатгалын салбарын гүнзгийрэлт нь даатгалын зах зээлийн хөгжлийг илэрхийлдэг ба дэлхийн улс орноор ялгаатай буюу илүү өндөр хөгжилтэй орнуудад бусад улс, орнуудтай харьцуулахад өндөр байдаг. Swiss Re компанийн тооцоолсоноор 2024 онд дэлхийн даатгалын гүнзгийрэлтийн түвшин 6.5% орчим байна. 2022 онд АНУ-д хамгийн өндөр буюу 12% байсан бол хөгжиж буй зах зээлд жишээлбэл, Энэтхэгт 2023-2024 онуудад 3.8% бол манай улсын хувьд 2024 оны байдлаар 0.64%-тай байна.

Swiss Re, Munich Re компаниудын тайлангаас харахад дэлхийн даатгалын зах зээл 2024 онд тогтвортой өсөлттэй байсан бөгөөд нийт хураамжийн хэмжээ ойролцоогоор 7.0 их наяд ам.долларт хүрсэн нь 2023 оны 6.8 их наядаас бага зэрэг буюу 3%-4%-иар өссөн үзүүлжээ.

Санхүүгийн Зохицуулах Хорооноос эрхлэн гаргасан 2024 оны даатгалын зах зээлийн тайланд ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ 24.2%-иар өсөж 582.3 тэрбум төгрөгт хүрсэн нь салбарын нийт хөрөнгийн 88%-ийг бүрдүүлж байна.

Тэнгэр даатгал компанийн хөрөнгө 2024 оны эцсийн байдлаар 56.1 тэрбум төгрөгт хүрч, ердийн даатгалын 17 компанийн нийт хөрөнгийн 8.5%-ийг бүрдүүлэн гуравдугаарт эрэмбэлэгдэж байна. Өөрөөр хэлбэл, манай компанийн хөрөнгө сүүлийн 9 жилийн хугацаанд жилд дундажаар 20%-иар тогтвортой өссөн байна.

2024 онд Тэнгэр даатгал нь олон нийтэд нээлттэй компани болсон нь бидний үүрэг хариуцлага нэмэгдэхийн зэрэгцээ бид бүхний нийгэмд болон байгаль орчинд эерэг нөлөөлөл бий болгох, компанийн ажилтнууд, хувьцаа эзэмшигч, харилцагчдын эрх ашгийг дээдлэх зэрэг олон боломжууд нээгдэж байна.

Тогтвортой хөгжлийн хүрээнд бид бүхэн дараах зорилтуудыг компанийн үйл ажиллагааны хүрээнд болон нийтэм, байгаль орчны сайн сайхны төлөө биелүүлэн ажиллажээ.



ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧИН, НӨХӨН СЭРГЭЭЛТ

2021 онд компани үүсэн байгуулагдсаны 20 жилийн ой баярыг тохиолдуулан хэрэгжүүлсэн томоохон үйл ажиллагааны нэг нь бид нийт харилцагч, түншүүдтэйгээ хамтран мод тарьж, төгөл байгуулсан явдал юм. Тодруулбал, хэмжээгээрээ азидаа 6-д ордог, 973 га талбай бүхий Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд Тэнгэр даатгал компани 3 га газарт өөрийн нэрэмжит “Тэнгэр Төгөл” байгуулж мод тарих, тохижуулах, усалгааны системийг нь бүрэн шийдэх, тарьсан модоо арчлах тус тус ажлыг хариуцан ажилласан.

Энэхүү мод тарих ажил нь 2021 онд манай компанийн урилгаар харилцагч, түншүүдийг төлөөлж 150 гаруй хүнтэй, мөн 2022 оны хаврын тарилтад ХасБанктай тус тус хамтран, 2023 онд бие даан шар хуайс, хайлаас, улиас, бургас, далан хальс, голт бор зэрэг 11 нэр төрлийн 1,550 модыг тарьсанаар амжилттай хэрэгжсэн.

Тэнгэр Төгөлд тарьсан бүх модыг What3word (3 үгт хаяг) ашиглан цахим бүртгэл, эзэнжүүлэлт хийж харилцагчдадаа өгсөн нь байгальд хог хаягдал тарихгүй, шинэлэг шийдэл болжээ.

Компанийн зүгээс цаашид Тэнгэр Даатгалыг сонгон даатгалын үйлчилгээ авсан харилцагч бүрийн төлсөн хураамжийн тодорхой хувийг “Тэнгэр Төгөл”-д мод тарих, тарьсан модоо услах, арчлах, нөхөн сэргээлт хийхэд зориулахаар төлөвлөсөн билээ. Өөрөөр хэлбэл, олон мянган харилцагчид, түншүүдтэйгээ хамтран Улаанбаатар хотынхоо ногоон байгууламжид өнгө нэмсэн, иргэд амарч зугаалах боломжтой жишиг төгөл байгуулах урт хугацааны зорилготой юм.

Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн ажилтан, мэргэжилтнүүдтэй хамтран тогтмол цэнэг усалгаа хийдэг бөгөөд Тэнгэр төгөлд тарьсан модны ургалт 100% байна гэж дүгнэж байна.

ХасБанктай хамтран Эрчим хүчний хэмнэлтийн даатгалыг нэвтрүүлсэн.

НҮБ-ын Уур Амьсгалын Ногоон Сангийн магадлан итгэмжлэгдсэн үндэсний хэрэгжүүлэгч байгууллага болох ХасБанк эрчим хүчний хэмнэлтийн даатгалын механизмыг Тэнгэр даатгал компанитай хамтран Монголд анх удаа нэвтрүүлж, олон нийтэд танилцуулах арга хэмжээг 2023 онд амжилттай зохион байгуулсан.

Эрчим хүчний хэмнэлтийн даатгалын тогтолцоо, түүнд оролцогч талуудад бий болох давуу тал болон даатгалын механизмын цахим платформын талаар танилцуулсан ба уг арга хэмжээнд төслийн зөвлөх, НҮБ-ын Байгаль Орчны Хөтөлбөрийн Хамтын ажиллагааны төв болох "BASE" ТББ болон төслийг хэрэгжүүлэгч ХасБанк, Тэнгэр Даатгал, Юрика байгууллагуудын төлөөллүүд илтгэл тавьж, эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмж, технологи нийлүүлэгч болон худалдан авагч, Санхүүгийн зохицуулах хороо, Эрчим хүчний зохицуулах хороо зэрэг холбогдох талуудад нэгдсэн ойлголт, мэдээлэл өгөн ажилласан байна.

Эрчим хүчний хэмнэлтийн даатгалын механизм нь зөвхөн даатгалын бүтээгдэхүүн бус санхүүгийн болон бусад механизмыг хослуулан сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх гол хөшүүрэг юм.

ГУРАВ. НИЙГЭМ

Хүний нөөцийн бодлого, менежмент

Бид Монгол Улсын санхүүгийн салбар, тэр дундаа даатгалын салбарыг хөгжүүлэх, иргэд олон нийтийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх чухал үүрэг хариуцлагыг үүрэн ажиллаж байна. Уг үүрэг даалгаврыг хэрэгжүүлэхийн тулд бид чадварлаг хүний нөөцөөр багаа бүрдүүлсэн байх шаардлагатай.

2024 онд шинээр бий болгосон ажлын байрны тоо 5.

- Ажилтнуудаа тодорхой хэмжээний мөнгөн хуримтлалтай байлгах зорилгоор "Ажилтны хуримтлал"-ын хөтөлбөр хэрэгжүүлдэг бөгөөд байгууллагаас болон ажилтан өөрөө ижил хэмжээгээр хуримтлалын санд сар бүр мөнгөн хуримтлал хийдэг. Энэ нь ажилтнууддаа чиглэсэн нийгмийн хариуцлагын өндөр ач холбогдолтой хөтөлбөр бөгөөд ажилтны тогтвор суурьшилтай, ирээдүйдээ итгэх итгэлтэй, амьдралын баталгаатай, ажилдаа сэтгэл хангалуун ажиллаж амьдрах бололцоог олгосон хүний нөөцийн бодлогын бодит илрэл юм.
- Нийт ажилтнуудынхаа ажиллах эрч хүч, тасралтгүй сурч хөгжих, шинийг санаачлах, хамт олонч багийн уур амьсгалыг бий болгох үүднээс 2020 оноос "Сайн сайхан оршихуй", 2021 оноос "Ментор" хөтөлбөрийг тус тус хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд мэргэжлийн болоод хувь хүний хөгжлийн сургалт, багийн үйл ажиллагааг дэмжсэн хөтөлбөрүүдийг тогтмол зохион байгуулж байна.
- Ажиллах орчны аюулгүй нөхцлийг бүрдүүлэхэд анхааран ХАБЭА-н сургалтуудыг зохион байгуулж, компаниасаа хариуцсан ажилтан томилон, холбогдох мэргэжлийн сургалтад хамруулж, албан ёсны сертификаттай болсон.
- Ажлын байрны эрсдэлийг бууруулах, галын аюулгүй байдлыг хангах зорилгоор ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, дүүргийн Онцгой байдлын хэлтэстэй хамтран аюул, гамшгаас урьдчилан сэргийлэх онолын сургалтыг амжилттай зохион байгуулсан. Мөн энэ ажлын хүрээнд галын аюулгүй байдлыг хариуцсан ажилтныг томилж, оффисын өрөө, коридоруудад авралтын зам гарцын схем зураг, чиглэлийн гэрэлтүүлэгч тэмдэглэл, галын аюулгүй байдлын самбарыг байрлуулж, ажилчдад таниулах мэдээлэл өгсөн.
- Бүх ажилтнуудаа хянан нийцүүлэлтийн сургалтыг гаднын мэргэжлийн байгууллагаас болон дотроо зохион байгуулан хамруулсанаар ажилтан бүр Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу сэжигтэй гүйлгээний талаар мэдээлэх үүргээ байнга хэрэгжүүлэн ажилладаг.

Салбарын онцлог болон үйл ажиллагааны хүрээнээс шалтгаалж манай компанийн нийт ажилчдын тоо 106 бөгөөд үүний 60% нь эмэгтэйчүүдээс бүрдэж байна. Дундаж нас 30 байна.

Нийгмийн хариуцлага

- "Зүрх Мартахгүй" төсөлд хандив өгөв.

Төрөлхийн зүрхний гажиг нь дэлхийд 100 төрөлт тутамд 1 тохиолддог. Монгол улсад жилдээ дунджаар 1,000 зүрхний төрөлхийн гажигтай хүүхэд төрдөг ба 20-30% нь зайлшгүй хагалгаанд орох шаардлагатай байдаг ажээ. Харин “Зүрх Мартахгүй” төсөл нь 2020 оноос эхлэн хүүхдийн зүрхний төрөлхийн гажгийг үнэ төлбөргүй эмчлэх санаачилга гарган ажиллаж, 1,139 бяцхан хүүхдэд амжилттай хагалгаа хийсэн байна. Тэнгэр Даатгал компани нийгмийн хариуцлагын хүрээнд энэхүү ажлыг дэмжиж “Зүрх Мартахгүй” төслийн хамт олонд 20.0 сая төгрөг хандивлалаа.

- **Амь эрсэдсэн гурван албан хаагчийн ар гэрт мөнгөн тусламж олгов.**

Өргөсөн тангарагтаа үнэнчээр зүтгэн, албан үүргээ гүйцэтгэж яваад харамсалтайгаар алтан амиа алдсан Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтсийн гал түймэр унтраах, аврах 63 дугаар ангийн 3 албан хаагчийн ар гэрт Тэнгэр даатгалаас нийт 150.0 сая төгрөгийн буцалтгүй мөнгөн тусламж олгосон.

Тэнгэр Даатгал компанийн хамт олны зүгээс Монгол улсын эрсдэлийг бууруулахын төлөө мөр зэрэгцэн зүтгэдэг зорилго нэгт гурван анд нөхдийнхөө гэгээн дурсгалд зориулан энэхүү мөнгөн тусламжийг олгохоор шийдвэрлэсэн билээ.

ДӨРӨВ. ИРГЭДИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖСЭН ТӨСЛҮҮД

- **“Эрсдэл ба Стандарт” форумыг 2023 онд амжилттай зохион байгуулав**

Манай улсад төдийгүй дэлхий дахинаа тулгамдаж буй нэн тэргүүний асуудлын нэг гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд стандарт мөрдүүлэх явдал нэн чухал байна. Энэ хүрээнд Монгол Улсын Шадар сайдын ивээл дор “Эрсдэл ба Стандарт” үндэсний чуулганыг 2023 оны 11 дүгээр сард орон даяар гурван өдөр зохион байгуулагдсан. Төрийн ордонд болсон “Эрсдэл ба стандарт” үндэсний форумд холбогдох яам, агентлаг, 21 аймгийн төр захиргааны болон олон улсын байгууллагын төлөөлөл, эрдэмтэн судлаачид, “Мандал санхүүгийн нэгдэл” тэргүүтэй хувийн хэвшил, бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжүүд, Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл, иргэний нийгмийн байгууллагын 2,400 гаруй оролцогч оролцжээ.

- **Монгол улсын ирээдүй болсон өсвөр насныхандаа зориулсан “ASUUNA” төсөл**

Тэнгэр даатгалын зүгээс нийгмийн хариуцлагын хүрээнд өсвөр насны хүүхдүүдэд зориулан “ASUUNA” төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Өсвөр нас нь хүүхдээс насанд хүрэгчдийн эгнээнд шилжих өсөлт бойжилт, сэтгэл санааны хамгийн чухал үе билээ. Энэ үед хүүхдийн бие физиологи, сэтгэлзүй, харилцаа, хандлага гэх мэт олон гэнэтийн өөрчлөлтүүд гарч улмаар сэтгэл гутралд орох, ааш зан өөрчлөгдөх, бүүр цаашлаад амиа хорлоход хүргэдэг.

Эдгээр болон бүүр цаашлаад эцэг эхтэйгээ хүртэл хуваалцаж чаддаггүй асуудлуудыг хэрхэн даван туулах болон мэдвэл зохих зүйлсийн талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх суваг дутмаг байдаг. Уг хэрэгцээ шаардлагыг үндэслэн бид 2022 оноос 13-18 насны хүүхдүүдэд эрүүл мэнд, нийгмийн харилцаа, сэтгэл зүйн асуултад нь хариулт өгөх зорилготойгоор “ASUUNA” төслийг нийгмийн хариуцлагын хүрээнд Тэнгэр Даатгалын зүгээс хэрэгжүүлэн ажиллаж байгаа билээ.

Үүний үр дүн бид давтагдсан тоогоор 315 мянган удаагийн зөвлөгөө зөвлөмжийг өсвөр насны хүүхдүүдэд хүргэсэн байна.

- **Монголын анхны эрүүл мэндийн нэгдсэн сан “EDoctor” веб хуудас**

Улс орны хувьд ард иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгож хэрхэн өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зэрэг мэдлэгийг олгох нь нэн чухал асуудал байдаг.

Уг хэрэгцээ шаардлагад үндэслэн бид бүх насныханд зориулсан эрүүл мэндийн боловсрол олгох цогц платформыг нэвтрүүлсэн нь Монголын хамгийн анхны эрүүл мэндийн нэгдсэн сан болсон билээ.

eDoctor - Вэбхуудас

edoctormn вэбсайт нь эрүүл мэндийн зөвлөмж, өвчний мэдээлэл, шинж тэмдгийн асуулга, эмнэлэг хайх, эрүүл мэндийн тооцоолуур гэсэн үндсэн 5 цэсээс бүрддэг. Бид өдгөө 1.5 сая гаруй тогтмол уншигчтай болсон бөгөөд мэргэжлийн эмч нарын бэлтгэсэн 250 гаруй өвчний дэлгэрэнгүй мэдээлэл, 100 гаруй зөвлөмж нийтлэл, шинж тэмдэг дээр суурилсан өвчний асуумж ба зөвлөмж, эрүүл мэндийн тооцоолуур, эмнэлэг хайх зэрэг олон зүйлийг нэг дор багтаасан өргөн мэдээллийн сантай болоод буй.

Үүний үр дүнд улиралд давтагдсан байдлаар 2.91 сая удаагийн хандалттайгаар иргэдийн эрүүл мэндийн боловсролд хөрөнгө оруулж, өвчлөлөөс урьдчилан сэргийлж байна.

eDoctor - Эрүүл мэндийн подкаст

Бид Монголын тэргүүлэх зэргийн нарийн мэргэжлийн эмч нартай хамтран Эрүүл мэндийн подкаст, 1 минут 1 асуулт, Хамгийн түгээмэл асуултууд зэрэг видео контентуудыг бэлтгэн Facebook, Instagram, Youtube зэрэг олон нийтийн сүлжээгээр цацаж олны хүртээл болгож байна.

Тус контентуудуудад Монгол Улсын болон хувийн тэргүүлэх эмнэлгүүдийн эмч мэргэжилтнүүд оролцон ард иргэдэд хамгийн түгээмэл тохиолддог өвчин эмгэгүүдийн талаар заавар зөвлөгөө өгдөг бөгөөд өдгөө зөвхөн 2024 онд давтагдсан тоогоор 7,330,902 хүнд хүрч үйлчилсэн байна.

- **“Mandal Student” төсөл**

Санхүү Эдийн Засгийн Их Сургууль болон Мандал Санхүүгийн Нэгдэл хамтран Банк Санхүүгийн бакалаврын зэрэг олгох тэтгэлэгт хөтөлбөрийг өнгөрөгч онд зарлаж 20 сурагчийг шалгаруулж, ажлын байраар ханган цалинжуулж, тэтгэлэг олгож байсан бол энэ онд тус хөтөлбөрийг дахин зарлан, мөн 20 сурагчийг ажлын байр, тэтгэлэг олгохоор элсэлт зохин байгуулан ажиллаж эхэллээ.

Тус хосолсон хөтөлбөр нь 3 жилийн хугацаанд Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн бакалаврын зэргийг авах, багийн ажиллагаа, бүтээмжтэй, өгөгч байх чадварт давхар суралцахаас гадна ажлын туршлагатай болох боломжтой гэдгээрээ Монгол улсад анхдагч нь болж байна.

- **Тэнгэр даатгал – цахим хуудас**

Тэнгэр даатгал веб хуудас:

Бид 2024 онд веб хуудсаа шинэ өнгө төрхтэйгөөр олон нийтэд танилцуулсан бөгөөд нээлттэй компанийн хариуцлагын хүрээнд нэмэлт “Хөрөнгө оруулагчдад” гэсэн цэсээр өргөтгөн мэдээ, мэдээлэл, тайланг цаг хугацаандаа тайлагнан ажиллаж байна.

Тэнгэр даатгал фэйсбүүк хуудас:

Фэйсбүүк сошл хуудас нь 85 мянга орчим дагагчтай, 1.9 сая орчим үзэгчтэй бөгөөд бид даатгалын нөхөн төлбөрийн мэдээлэл, эрсдэлийн тухай ойлголт, даатгалын бүтээгдэхүүний танилцуулга, зарлагдсан урамшууллын талаар болон баярын мэндчилгээ, сэрэмжлүүлэг мэдээллийг цаг тухайд нь мэдээлдэг.

ТАВ. ЗАСАГЛАЛ

Компанийн засаглал, бизнесийн үйл ажиллагааны амин чухал хэсэг нь хууль тогтоомж, дүрэм журмыг хэрэгжүүлэх явдал билээ. Манай компани нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн комплаенсийн журам боловсруулан баталж, компанийн бүх түвшинд мөрдүүлэн бэхжүүлэх, үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор комплаенсийн асуудал

хариуцсан ажилтан буюу Хянан нийцүүлэлтийн мэргэжилтний ажлын байрыг бий болгож комплаенсийн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Тэнгэр Даатгал компани Санхүүгийн Зохицуулах Хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 145 дугаар тогтоолоор батлагдсан "Компанийн засаглалын кодекс"-ыг үйл ажиллагаандаа баримтлан ажиллаж байна. Засаглалын кодексыг бүх ажилтан, албан тушаалтнууд сахин мөрдөх үүрэгтэй бөгөөд хэрэгжилтийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) хянадаг.

Компанийн ТУЗ нь засаглалын практикийг олон улсын жишиг болон ёс зүйн хэм хэмжээний хүрээнд хууль тогтоомжийн дагуу, тогтвортой, тууштай баримтлахыг үүрэг болгон ил тод, хариуцлагатай байдлыг эрхэмлэж, салбарын стандартад үлгэр жишээ соёлыг төлөвшүүлэхийг зорьдог.

Манлайлал

Компанийн засаглалын тогтолцоог бэхжүүлэх, ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажилладаг соёлыг төлөвшүүлэх чиг хандлагыг тодорхойлоход компанийн ТУЗ нь Гүйцэтгэх удирдлагын багтай нягт хамтран ажилладаг бөгөөд шударга ёс, шинийг санаачлагч, стратегийн алсын харааг зарчим болгосон шийдвэрийг ямагт хэрэгжүүлж байдаг.

Компанийн ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын баг нь цаг үетэй уялдуулан холбогдох дүрэм журмыг шинэчлэн үйл ажиллагаагаа явуулдаг ба ТУЗ-ийн бүрэлдэхүүн нь байгууллагын эрхэм зорилго, үнэт зүйлсийг эрхэмлэн дээдэлж, амжилт, тогтвортой байдалд чухал үүрэг гүйцэтгэдэг мэргэжлийн туршлагатай оролцогч талуудыг төлөөлсөн хараат бус гишүүдээс бүрдсэн байна.

Стратеги ба гүйцэтгэл

Компанийн хувьцаа эзэмшигчид солигдсонтой холбоотойгоор шинэ бодлого, стратегийг баримтлан үйл ажиллагаагаа явуулж байна. Стратеги шинэчлэлийн хүрээнд томоохон бодлого, журмуудыг шинэчлэн сайжруулсан. Үүнд, Ёсзүйн дүрэм, Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам, Аудит Эрсдэлийн хорооны журам, ТУЗ-ийн гишүүдийг нэр дэвшүүлэх, залгамж халааны журам, Ногдол ашгийн бодлого, Эрсдэлийн удирдлагын бодлого зэрэг болно.

Ёс зүй

Байгууллагын соёл, дотоод эерэг уур амьсгалыг бэхжүүлэх болон нийт ажилтны дагаж мөрдөн үйл ажиллагаандаа баримтлах чухал засаглал болон соёлын бодлогын баримт бичиг болох "Ёс зүйн дүрэм"-ийг ТУЗ-ийн 2023 оны 06 дугаар сарын 28-ны тогтоолын хавсралтаар баталсан нь компанийн ёс зүйн хэм хэмжээг дэмжин ажилладгийг нотолсон баримт бичгийн нэг юм.

Засаглалын тогтолцоо

Компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг бүх хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 3 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит бус хурлаар сонгож баталсан гишүүдээр бүрдүүлсэн. Энэ нь ТУЗ-ийн тогтолцоо нэг талын нөлөөнд автсан шийдвэр гаргах эрсдэлгүй, хамгийн эрүүл гэдгийг батлан харуулж байна. ТУЗ-ийн удирдан чиглүүлэх үндсэн ажлыг гүйцэтгэхэд өндөр хувь нэмэр оруулахуйц санхүүгийн мэргэшсэн мэргэжилтнүүдээр зөвлөлөө бүрэлдүүлсэн.

2024 онд "Тэнгэр Даатгал" ХХК-ийн ТУЗ нийт 14 удаа ээлжит болон ээлжит бус байдлаар хуралдаж, 37 асуудлыг шийдвэрлэн тогтоол гарган ажилласан байна.

Тайланг дүгнэсэн:

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ



О.БАТЖАРГАЛ

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Энэхүү тайлан нь “Монголын хөрөнгийн бирж” ХХК-д бүртгэлтэй компаниудын байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын чиглэлээр тайлант хугацаанд авч хэрэгжүүлсэн стратеги арга хэмжээ, нөхцөл байдлыг хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид, олон нийтэд ил тод нээлттэй тайлагнах зорилготой. Хэсэг 1, 2, 3 нь нийт үнэт цаас гаргагч компаниудад хамааралтай бөгөөд Хэсэг 4 нь зөвхөн тухайн салбарт үйл ажиллагаа явуулж буй үнэт цаас гаргагчдад хамаана. Хэрэв тайлангийн маягтад заасан аливаа мэдээллийг цуглуулах, тайлагнах боломжгүй бол тайлагнах боломжтой талаарх тайлбар, цаашид мэдээллийг тайлагнах чиглэлд авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар “тайлбар” хэсэгт бичнэ үү.

Огноо (он, сар, өдөр):	2025/04/30
Үнэт цаас гаргагчийн нэр:	"Тэнгэр даатгал" ХК
Үнэт цаасны нэр, код (МХБ симбол):	TGI
Салбарын ангилал:	МХБ-ийн II ангилал
Тайланд орсон компаниуд (энэхүү тайланд орсон толгой болон охин компаниудын мэдээлэл):	"Тэнгэр даатгал" ХК
Тайлангийн хамаарах хугацаа:	2024/01/01-2024/12/31
Хариуцсан албан тушаалтны овог нэр, албан тушаал, холбоо барих и-мэйл хаяг, утас:	О.Батжаргал Тогтвортой хөгжил хариуцсан захирал Имэйл: batjargal.ojd@tengerdaatgal.mn Утас: 99007524
Тайланг баталгаажуулсан гүйцэтгэх удирдлагын мэдээлэл (нэр, албан тушаал):	Б.Баянмөнх Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч
Гүйцэтгэх удирдлага эсвэл ТУЗ-ийн даргын гарын үсэг:	(гарын үсэг)

	Бүлэг	Шалгуур үзүүлэлтүүд		Үзүүлэлт (өмнөх он)	Үзүүлэлт (тайлант он)	Хэмжих нэгж	Нэмэлт мэдээлэл	Тайлбар	Холбоос
	Тогтвортой хөгжлийн удирдлагын системтэй холбоотой шалгуур үзүүлэлтүүд								
MS1.1	Тогтвортой хөгжлийн удирдлагын тайлан	Удирдлагын амлалт	Удирдлагаас баталсан тогтвортой хөгжлийн амлалт/мэдэгдэл байдаг эсэх	-	1. Тийм		2023 онд шинэчлэн баталсан Ёсзүйн дүрэмдээ "Нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгчийн хувьд өгөх амлалт", "Зах зээл буюу даатгуулагчиддаа өгөх амлалт", "Ажилтнууддаа өгөх амлалт", "Хувьцаа эзэмшигчиддээ өгөх амлалт"-уудаа мөн тодорхойлж олон нийтэд нээлттэй байршуулан ажилладаг.		GRI 102
MS2.1		Тогтвортой хөгжлийн бодлого, зохицуулалт	Тогтвортой хөгжлийн бодлого, зорилтуудыг тодорхойлж баталсан эсэх		1. Тийм		https://www.tengerdaatgal.mn/investment		GRI 103, ISO 14001
MS2.2		Бүтэц удирдлага	Танай компани тогтвортой хөгжлийн асуудал хариуцсан хорсо байдаг эсэх		2. үгүй			Тогтвортой хөгжил, БОНЗ-ын асуудал хариуцсан захирлаар компанийн Гүйцэтгэх захирлыг томилон ажилладаг.	GRI 103, ISO 14001
MS3.1			ТУЗ-ийн түвшинд тогтвортой хөгжил / БОНЗ-ын асуудал хариуцсан гишүүн (бүтэн)		1. Тийм		ТУЗ-ийн дарга		GRI102

			цагийн/хэвсрэн) байдаг эсэх						
MS3.2			Гүйцэтгэх удирдлагын түвшинд тогтоотой хөгжил/БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/хэвсрэн) байдаг эсэх		1. Тийм		Гүйцэтгэх захирал	GRI102	
MS3.3			Үйл ажиллагааны түвшинд тогтоотой хөгжил/БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/хэвсрэн) байдаг эсэх		1. Тийм		Эрсдэл хариуцсан захирал	GRI102	
MS3.4			Танай компани ТУЗ-ийн хурлын хөтөлбөрт тогтвортой хөгжлийн асуудлыг албан ёсоор тусгадаг уу?		1. Тийм		https://www.tengerdaatgal.mn/investment	GRI102	
MS3.5		Тогтвортой байдлын нөлөөллийн үнэлгээ	Танай компани эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллөөс хэрхэн зайлсхийх, бууруулах, арилгах, зөрөг үр нөлөөг сайжруулах талаар тайлбарласан нөлөөллийн үнэлгээ эсвэл матриц байдаг эсэх		1. Тийм		Манай компани эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг дэмжихгүй байхад анхаарч, үүнтэй холбоотойгоор даатгалын тохиолдолд нөхөн төлбөр олгохгүй байхаар даатгалын гэрээндээ дараах байдлаар тусган ажилладаг. Үүнд: - Нийгмийн эмх замбараагүй байдал, ажил хаялт, гэмт халдлага, төрийн эргэлт, үймээн, самуун, бослого, хөдөлгөөн, хувьсгал, маргаан, булаан эзлэх, барьцаалах, баривчлан саатуулах, дайн, дайны шинжтэй тэмцэл, тэсрэх бөмбөг дэлбэлэх, террорист, улс төрийн үйл ажиллагаа болон нийтээр нүүлгэн шилжүүлэхээс үүдсэн хохирол; - Мин, тропед, бөмбөг эсвэл бусад тэсрэх бодис, байлдааны зэвсэг, тэдгээрийн үйлчлэлээс үүдсэн хохирол; - Атом ба цөмийн энергийн бүхий л эрсдэл, цөмийн урвал, цацраг, цацраг идэвхт болон хими, химийн хорт, бислсги, био-химийн бодис, тэдгээрийн бохирдол, үр дагавраас үүдсэн хохирол; - Асбест, асбест агуулсан ямар нэгэн материалаас болон тэдгээрийн үр дагавраас үүдсэн хохирол зэрэг болно.		SASB
MS4.1		Чадаах бүрдүүлэлт	Нэг ажилтанд ногдох тогтвортой хөгжлийн тухай сургалтын жилийн дундаж цаг, хүйсээр		4	цаг	Захиргаа, санхүүгийн газрын захирал, эмэгтэй-1 Нэг ажилтанд 4 цаг, эмэгтэй	GRI 102	
MS4.2		Хяналт	Тогтвортой байдлын асуудал нь		1.Тийм		ТУЗ-ийн дэргэдэх Аудит, Эрсдэлийн хорооны журамд тус хорооны үүргийг "... хууль, дүрэм, журмын хэрэгжилтэд компанийн зүгээс	GRI 102, SDG 12	

			аудитын хорооны үйл ажиллагаа, дотоод хяналтын чиг үүрэгт хамаардаг уу?				тавих хяналтын үйл ажиллагаа болон компанийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг дахин хянан нягтлах" гэж заасан.		
MS4.3		Тогтвортой байдлын тайлагнал	Танай компани тогтвортой байдал/ хөгжлийн тайлан (жилийн тайланд нэгтгэдэг эсвэл тусдаа тайлан)-гаа жил нэгээс доошгүй удаа тайлагнадаг уу?		1.Тийм		Жилийн тайландаа нэгтгэдгээс гадна МХБ-д тусдаа тайлан бэлтгэн хүргүүлсэн.		GRI 102, SDG 12
MS5.1			Танай компани олон улсын уур амьсгалын эрсдэлийн стандартын дагуу тайлагнадаг уу?		1.Тийм		Компанийн БОНЗ-ын тайланд тодорхой тусгагдсан.		GRI 102, SDG 12
MS5.2		Гишүүнчлэл, хамтын ажиллагаа	Танай компани тогтвортой хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын болон дотоодын холбоо, нэгдэлтэй нэгдэж хамтран ажилладаг уу?		1.Тийм		Тогтвортой байдлын тайлагнал, удирдлагын төв НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн Тогтвортой байдлын төлөөх санхүүгийн төв (UNDP FC4S) хэрэгжүүлж буй "Тогтвортой байдлын тайлагнал, удирдлагын төв" (SDMH) хөтөлбөрт хамрагдсан.		GRI 102, SDG 17
MS6.1	Байгаль орчны шалгуур үзүүлэлтүүд								
E1.1	Эрчим хүч	Нийт эрчим хүчний хэрэглээ	Эрчим хүчний нийт зарцуулалтын хэмжээ болон зардал	-	-	Mera Втц '000	Төвлөрсөн эх үүсвэрээс цахилгаанаа хангадаг бөгөөд бид 2020 онд төв салбарын байрандаа их засвар хийхдээ цахилгааны хэмнэлттэй LED гэрэлтүүлэгч, мөн агааржуулалт, дулааны оновчтой шийдлийг сонгосноор нэмэлт агааржуулалт, дулааны эх үүсвэр шаардлагагүй болсон. Ингэснээр 14%-ийн хэмнэлт гаргасан байна. *- тухайн жилд төлсөн зардлаас ойролцоогоор тооцож гаргасан дүн болно.		GRI 302, SDG 12
E1.2		Цахилгаан	Цахилгааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	~45,240.08*	~38,772.98*	Mera Втц			GRI 302, SDG 12
E1.3		Дулаан	Дулааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	~4,319.34*	~4,865.35*	BTU & % Гкал	2024 онд нэмэлтээр талбай түрээслэх болсоноор зардал нэмэгдсэн. *- тухайн жилд төлсөн зардлаас ойролцоогоор тооцож гаргасан дүн болно.		GRI 302, SDG 12
E1.4		Түлш	Түлшний нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	~8,777.06л* 34,3* 8,305.22 төгрөг	~5,364.72л* 20,976,064.05 төгрөг	Литр/кг & %, ГЖоуль, Төгрөг	Манай компани төр засгийн шийдвэрийг хариуцлагатайгаар биелүүлэн ажилладаг тул зөв талдаа жолооны хүрдтэй, хайбрид хосолсон хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийг үйлчилгээтэй ашигладаг. *- тухайн жилд төлсөн зардлаас ойролцоогоор тооцож гаргасан дүн болно.		GRI 302, SDG 12
E1.5		Хүрэн эрчим хүч	СЭХ-ээс бусад эх үүсвэрээс авсан	-	-	-	-	Төвлөрсөн эх үүсвэрээс цахилгаанаа хангадаг	SFRD

			эрчим хүчний хэрэглээний хувь						
E1.6		Сэргээгдэх эрчим хүч	СЭХ үүсвэрээс гаргаж авсан эрчим хүчний хэрэглээний хувь	-	-	-	-	Төвлөрсөн эх үүсвэрээс цахилгаанаа хангадаг	GRI 302, SDG 7
E2.1	Хүлэмжийн хийн ялгарал	3.1 Хүлэмжийн хийн ялгаруулалт	Компанийн шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан нийт хүлэмжийн хийн дүн	26,321.18 кг CO2	16,094.17 кг CO2	CO2/тонн	1 л түлш шатаахад 3 кг CO2 ялгардаг. Манай компанийн нийт 5 автомашин 2024 онд 5,364.72 л түлш зарцуулсан гэж тооцвол 16,094.17 кг CO2 хүлэмжийн хий ялгаруулсан байна. Энэ нь 2023 оны үзүүлэлтийг 39%-иар бууруулсан байна.	-	GRI 305, SDG 13, WRI/WBCSD GHG protocol.
E2.2		3.2 Бууруулсан хүлэмжийн хий	Байгууллагын шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан хүлэмжийн хийн нийт дүн (жилээр)	-	-10,237.02 кг CO2	CO2/тонн		-	GRI 305, SDG 13, WRI/WBCSD GHG protocol.
E2.3		3.3 Дүйцүүлэх арга хэмжээ /Карбон офсет/	Нийт карбон офсет буюу дүйцүүлэх арга хэмжээний (мод тарих хөтөлбөр, эсвэл хүлэмжийн хийг бууруулах гаднын төслийг дэмжих гэх мэт)бууралт			CO2/тонн	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг бүрэн дэмжиж ажилласан ба манай компани 2021 оноос хойш Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 3 га газар төгөл үүсгэн байгуулж услалтын системийг шийдэж, мод тарих, арчлан ургуулах төслийг өөрийн хөрөнгөөрөө хэрэгжүүлж эхэлсэн. "Тэнгэр төгөл"-д 6 нэр төрлийн 500 ширхэг модны суулгац тарьсан ба тогтмол усалгаа, арчилгаа хийсний үр дүнд 100% ургахын зэрэгцээ адил хугацаанд тарьсан модноос өндөр ургалттай байгааг дуулгахад таатай байна. 2022 оны хаврын тарилтад ХасБанк хамтран оролцож Өрөл, Голтбор (150ш), Далан хайс (150ш), Шар хуайс(160ш), Хайлаас (110ш), Улиас (50ш), Бургас (30ш) зэрэг 7 нэр төрлийн 800 мод нэмж тарьснаар нийтдээ 10 төрлийн 1,300 модтой болсон.		GRI 305, SDG 13, WRI/WBCSD GHG protocol.
E3.1	Уур амьсгалын өөрчлөлт	Уур амьсгалын бодлого, журам	Танай компани уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тусдаа эсвэл бусад журамд тусгасан бодлоготой юу?		2.Үгүй			Манай компани 2011 оноос эхлэн "Нийгэм, байгаль орчны удирдлагын бодлого" боловсруулан батлуулснаас хойш 14 дэхь жилдээ амжилттай ажиллаж байна. Энэхүү бодлогын хүрээнд цаасны хэрэглээг багасгаж цахим шилжилт рүү шилжүүлснээр харилцагчдын сэтгэл ханамж дээшилж, харилцагчдын тоо жилээс жилд өсөн нэмэгдсээр байна.	GRI 201, TCFD, SDG 13
E3.2		Уур амьсгалын эрсдэл ба боломжийн үнэлгээ	Танай компани уур амьсгалын эрсдэл, боломжийн талаарх үнэлтээ хийсэн үү? (сценарийн шинжилгээ, стресс тест гэх мэт)		2.Үгүй				GRI 201, TCFD, SDG 13
E3.3		Эдийн засгийн хохирол	Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг, үйл явдлын улмаас учирсан эдийн засгийн нийт			Төрөг	-	-	GRI 201, TCFD, SDG 13

E3.4		Уур амьсгалын хөрөнгө оруулалт	Уур амьсгалын өөрчлөлтийн эсвэл дэд бүтэц, дасан зохицол, бүтээгдэхүүн хөгжилд оруулсан нийт хөрөнгө оруулалтын дүн			Төрөг	-		GRI 201, TCFD, SDG 13
E3.5		Уур амьсгалын өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх эсвэл дасан зохицох	Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор танай компанийн ашигт ажиллагаа эсвэл бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт нөлөөлөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, (хэрэв урьдчилан сэргийлэх боломжгүй бол, дасан зохицох чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээ/алхмуудыг тодорхойлсон уу?		2.Үгүй		-		GRI, SASB, World Economic Forum
E4.1	Ус	Усны хэрэглээ	Ашигласан усны нийт хэмжээ	~227,063.5л*	~330,169.3л*	м3/Л	-	*- тухайн жилд төлсөн цэвэр болон бохир усны зардлаас ойролцоогоор тооцож гаргасан дүн болно.	GRI 303, SDG 6
E4.2		Хэмнэсэн ус	Хэмнэлт, үр ашгийг дээшлүүлснээр нийт хэмнэсэн/дахин боловсруулсан усны хэмжээ			м3/Л	-	Ажилтнууддаа усаа хэмнэх талаар байнга сануулж, ус хэрэглэдэг хэсгүүдэд сануулга, зөвлөмж байршуулж ажилладаг.	GRI 303, SDG 6
E4.3		Дахин боловсруулсан ус	Дахин ашигласан болон боловсруулсан усны эзлэх хувь	-	-	-	-	Нэгдсэн системд холбогдсон тул хэрэглэсэн усыг дахин боловсруулах боломжгүй байдаг.	GRI 303, SDG 6
E4.4		Хаягдал бохир ус цэвэрлэх	Цэвэрлэсэн нийт хаягдал бохир усны хэмжээ			м3/Л	-		GRI 303, SDG 6
E5.1	Хатуу хог хаягдал	Хог хаягдал	Нийт ялгаруулсан хог хаягдлын хэмжээ			тонн	-	Манай компанийн байрлаж буй барилгын хэмжээнд нэгдсэн байдлаар хог хаягдлыг гаргадаг тул хэмжих болон дахин боловсруулах боломжгүй байна. Харин бид хог хаягдлаа ангилж, ялгадаг.	GRI 306, SDG 12
E5.2		Дахин боловсруулсан хатуу хог хаягдал	Хог хаягдлыг дахин боловсруулсан хувь			%	-		GRI 306, SDG 12
E5.3		Хортой хог хаягдал	Хортой хог хаягдлын нийт хэмжээ (Үүнд цахилгаан хэрэгслийн хог орно)			тонн	Цахилгаан хэрэгслийн хог хаягдал болон зай, батареийг бид тусдаа ялган, ачуулдаг ба цахилгаан хэрэгслийг байнга дахин ашигладаг буюу хэрэгцээтэй газрууд руу нийлүүлдэг тул энэ төрлийн хог хаягдал бага гардаг.		GRI 306, SDG 12
E6.1		Ногоон байгууламж,	Байгаль орчны хувьд			%	Манай компани 2021 оноос хойш Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 3 га газар төгөл үүсгэн	GRI 304, SDG 15	

	Биологийн олон янз байдал	төлөвлөлт	тогтвортой ашиглаж буй нийтийн эзэмшлийн талбай буюу барьсан ногоон байгууламжийн талбайн нийт талбайд эзлэх хувь				байгуулж усалтын системийг шийдэж, мод тарих, арчлан ургуулах төслийг өөрийн хөрөнгөөрөө хэрэгжүүлж эхэлсэн.		
E6.2		Зэрлэг ургамал, амьтдыг хамгаалах	Хамгаалсан төрөл зүйлийн тоо			Төрөл зүйлийн тоо	-	-	GRI 304, SDG 15
E6.3		Биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлж буй үйл ажиллагаа	Тусгай хамгаалалттай газар нутаг, биологийн олон янз байдал, соёлын үнэ цэнэ өндөртэй газар нутгийг эзэмшиж, түрээсэлсэн, удирдаж байгаа эсвэл зэргэлдээх үйл ажиллагааны талбайн нийт талбайд эзлэх хувь			%	-	-	SFRD, IFC Performance Standard 6
Нийгмийн шалгуур үзүүлэлтүүд									
S1.1	Хүний нөөц	Хүний нөөцийн тогтвортой байдал	Үндсэн ажилтнуудын ажлын байрны сэлгээний хувь (тухайн снд ажлаасаа гарсан ажилтнуудын тоог ажилласан ажилтнуудын дундаж тоонд хуваах)	-	6%	%	2024 онд хүний нөөцийн эргэц 6%-тай байна.		GRI 401, SDG 8
S1.2		Шинээр бий болгосон ажлын байр	Өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн бүтэн цагийн ажлын байрны тоо	-	5	Тоо			GRI 401, SDG 8
S1.3		Сургалт	Нэг ажилтанд ногдох жилийн дундаж сургалтын цаг		5	цаг			GRI 401, SDG 8
S2.1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА)	ХАБЭА-н бодлого	ХАБЭА-н бодлого, журем бий юу (тусдаа бодлого журем эсвэл ал нэг журамд нэгтгэсэн)?		1.Тийм		https://tengerinsurance.sharepoint.com/ Энэхүү вэбэд суурилсан платформд байршуулан баримт бичгээ танилцуулдаг.		GRI 103, SDG 10
S2.2		Осол аваар	Үйл ажиллагааны явцад гарсан	-	-	%	Ажиллах орчны аюулгүй нэхцлийг бүрдүүлэхэд анхааран ХАБЭА-н сургалтуудыг		GRI 403, SDG 3

			осол аваарын хувь				зохион байгуулж, компаниасаа хариуцсан ажилтан томилон, холбогдох мэргэжлийн сургалтад хамруулж, албан ёсны сертификаттай болсон. Ажлын байрны эрсдэлийг бууруулах, галын аюулгүй байдлыг хангах зорилгоор ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, дүүргийн Онцгой байдлын хэлтэстэй хамтран аюул, гамшгаас урьдчилан сэргийлэх онолын сургалтыг амжилттай зохион байгуулсан. Мөн энэ ажлын хүрээнд галын аюулгүй байдлыг хариуцсан ажилтныг томилж, оффисын өрөө, коридоруудад авралтын зам гарцын схем зураг, чиглэлийн гэрэлтүүлэгч тэмдэглэл, галын аюулгүй байдлын самбарыг байрлуулж, ажилчдад таниулах мэдээлэл өгсөн.		
S2.3		ХАБЭА-н сургалт	Жилд нэг ажилтанд нэгдөх дундаж ХАБЭА сургалтын цаг		2	цаг			GRI 403, SDG 3
S2.4		Эрүүл мэндийн хөтөлбөр	Эрүүл мэндийн үзлэг зэрэг сайн дурын эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан ажилчдын тоо жилээр	100	100	хүн	4 дэх жилдээ ажилтнуудаа Хаан даатгал ХХК-д гэнэтийн ослын, эмнэлэг эмчилгээний зардлын даатгалд хамруулан ажилладаг. Тус даатгалын гэрээгээр ажилтнууд жил бүр урьдчилан сэргийлэх үзлэг хамрагддаг.		GRI 403, SDG 3
S3.1	Эрх тэгш байдал	Жендерийн бодлого, журам	Жендерийн бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?		1.Тийм		https://tengerinsurance.sharepoint.com/ Энэхүү вэбэд суурилсан платформд байршуулан баримт бичгээ танилцуулдаг.	Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх бодлогод тусгасан байдаг.	GRI 405, SDG 5
S3.2		Ажлын байрны бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам	Бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?		1.Тийм		https://tengerinsurance.sharepoint.com/ Энэхүү вэбэд суурилсан платформд байршуулан баримт бичгээ танилцуулдаг.		GRI 103, SDG 5
S3.3		Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам	Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?		1.Тийм		https://tengerinsurance.sharepoint.com/ Энэхүү вэбэд суурилсан платформд байршуулан баримт бичгээ танилцуулдаг.		GRI 103,SDG 10
S3.4		Ажилтнуудын хүйсийн харьцаа	Нийт үндсэн ажилтнуудын тоонд эрэгтэй эмэгтэй ажилтны эзлэх хувь	60%-эм, 40%-эр	60%-эм, 40%-эр	%			GRI 405, SDG 5
S3.5		Удирдах зөвлөлийн хүйсийн харьцаа	Удирдах зөвлөлийн гишүүдийн эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	22%-эм 78%-эр	22%-эм 78%-эр	%			GRI 405, SDG 5

S3.6		Гүйцэтгэх удирдлагын хүйсийн харьцаа	Гүйцэтгэх удирдлагын түвшний ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	67%-эм 33%-эр	67%-эм 33%-эр	%			GRI 405, SDG 5
S3.7		Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын хүйсийн харьцаа	Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	60% -эм, 40%-эр	60% -эм, 40%-эр	%			GRI 405, SDG 5
S3.8		Жендерт суурилсан цалингийн зөрүү	Эрэгтэй ба эмэгтэй ажилтнуудын дундаж цалингийн харьцаа	50/50	50/50	харьцаа	Зөрүүгүй		GRI 405, SDG 5, SFRD
S4.1	Хүртээмжтэй байдал	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлого, журам	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?		2.Үгүй			Тусгайлсан бодлого, журам боловсруулж батлуулаагүй ч гэсэн Монгол улсын хууль, дүрмийн дагуу ажилладаг	SDG 10
S4.2		Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнууд	Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын нийт ажилтны тоонд эзлэх хувь	2	2	%			SDG 10
S4.3		Оффисын хүртээмж	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлаар шийдсэн оффис байгууламжтай юу		1.Тийм		Түрээслүүлэгч байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг тохижуулсан ба оффисоос орж гарах, цахилгаан шатаар зорчиход аливаа бэрхшээлгүй болно		SDG 10
S4.4		Торгууль	Байгаль орчны зөвшөөрөл, стандарт, дүрэм журмыг дагаж мөрдөөгүйгээс гарсан зерчлийн тоо			Төрөг		Аливаа торгууль болон хариуцлагын шийтгэлгүй ажиллаж байна.	SDG 10
S5.1	Нийгмийн хариуцлага ба ил тод байдал	Оролцогч талуудын оролцооны засаглал	Оролцогч талуудтай хамтарч ажиллах талаар тусгайлсан бодлого байгаа юу?		1.Тийм		Тэнгэр Даатгал ХХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 03 сарын 13-ны өдрийн BR/013 тогтсолын Хавсралт №2-оор баталсан.		IFC
S5.2		Нийгмийн нөлөөллийн үнэлгээ, газар чөлөөлөлтийн бодлого журам	Танай компани нийгэмд нөлөөлөх байдлын бодлого,		2.Үгүй		-	Ямар нэг хэлбэрээр газар эзэмшиж, өмчилж, түрээслэдэггүй болно.	IFC Performance Standards

			журамтай юу? (Үүнд газар чөлөөгөлт багтана)						
S5.3		Санал гомдлыг шийдвэрлэх бодлого/журам	Гомдол маргааныг шийдвэрлэх бодлого, механизм бий юу?		1.Тийм		"Харилцагчийн санал, гомдлыг шийдвэрлэх журам"-ыг 2019/4/22-ны Гүйцэтгэх удирдлагын хорооны хурлаар батлуулан ажиллаж байна.		GRI 102, SDG 16
S5.4		Олон нийтэд ил тод мэдээлэх	Танай компанийн үйл ажиллагаа нөлөөлж буй иргэдэд мэдээлэл өгөх, санал хүсэлт авч, гомдол шийдвэрлэх тогтолцоо бий юу?		1.Тийм		Компанийн https://www.tengerdaatgal.mn/ веб сайт болон https://www.facebook.com/@tengerinsurance/ фэйсбүүк пэйж хуудсаар дамжуулан аливаа мэдээ, мэдээллийг түгээдэг. Мөн үйл ажиллагаатай холбоотой харилцагчийн санал, гомдлыг 1800-1889 дугаарын утсаар хүлээн авч шийдвэрлэдэг.		IFC Performance Standards
S5.5		Ажилчид/олон нийтийн санал гомдол	Ажилчид болон олон нийтээс ирсэн санал гомдлыг шийдвэрлэсн хувь			100%		Ажилчдаас ирсэн санал, гомдлыг компанийн удирдлагууд Гүйцэтгэх захирлын дэргэдэх Гүйцэтгэх удирдлагын хорооны хурлаар хэлэлцэж шийдвэрлэдэг бөгөөд ТУЗ-д байнга мэдээллэдэг. Харилцагчаас ирүүлсэн санал гомдлыг "Харилцагчийн санал, гомдлыг шийдвэрлэх журам"-ын дагуу шийдвэрлэдэг. СЗХ-нд харилцагчид гомдол гарган шийдвэрлүүлдэг. 2024 онд СЗХ-д 19 өргөдөл, гомдол гаргасны 58% нь компанийн шийдвэр үндэслэлтэй болохыг тогтоон ажиллажээ.	GRI 413, SDG 8
S5.6		Нийгмийн хариуцлагын үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалт	Нийгмийн хариуцлагын арга хэмжээ, хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө оруулалтын нийт орлогод эзлэх хувь			%	1. Тэнгэр төгөл: Ирээдүй хойч үедээ амьсгалах цэвэр агаар, ногоон байгууламжийг үлдээх зорилготойгоор Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 3 га газарт 11 төрлийн 1,550ш модыг тарихдаа усалгааны системийг бүрэн шийдэж ажилласан. 2. Зүрх мартаггүй: Хүүхдийн зүрхний төрөлхийн гажгийг үнэ төлбөргүй эмчлэх санаачилга гарган ажиллаж буй "Зүрх Мартахгүй" төслийг дэмжиж төслийн хамт олонд 20 сая төгрөг хандивласан. 3. Edoctor платформ: Ард иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгож хэрхэн өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зэрэг мэдлэгийг олгох зорилготой хамгийн олон зөвлөмжийг багтаасан мэдээллийн санг бий болгосон. 4. Асуула платформ: 13-18 насны хүүхдүүдэд эрүүл мэнд, үерхэл нөхөрлөл, сэтгэл зүй, өсвөр насны хөгжлийн онцлогтой холбоотой үүсдэг олон асуултуудад хариу өгөх зорилго бүхий мэргэжилтнүүдийн бэлтгэсэн хамгийн их мэдээлэлтэй санд хөрөнгө оруулалт хийн хөгжүүлэн ажиллаж байна. 5. Эрсдэлийн форум: Мандал санхүүгийн нэгдлийн бусад компаниудтай хамтран жил бүр манай улсад төдийгүй дэлхий дахинаа тулгамдаж буй нэн тэргүүний асуудлын нэг гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилго бүхий үйл ажиллагааг амжилттай		GRI 413, SDG 8

							зохион байгуулан ажилладаг. 6. Хандив, тусламж: албан үүргээ гүйцэтгэж яваад харамсалтайгаар алтан амиа алдсан ОБГ-ын 3 албан хаагчдын ар гэрт 150.0 сая төгрөгийн мөнгөн тусламж олгосон. 7. Тэтгэлэгтэй оюутан: Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцаж буй оюутнуудаас 20 оюутныг шалгаруулан 3 жилийн хугацаанд бакалаврын зэргийг авах, мөн ажлын туршлагатай болох боломжтой Монгол улсад анхдагч тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.		
S6.1	Тогтвортой өртгийн сүлжээний менежмент	Худалдан авалтын бодлого, журам	Танай компанид дотоодын худалдан авалт болон тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн эрсдэл боломжийг хангасан худалдан авалтын бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?		2.Үгүй			Манай компани үндэсний үйлдвэрлэгчдээ 100% дэмжин ажилладаг. Энэ хүрээнд харилцагчдад өгөх гарын бэлэгтээ "Боса кондитер" ХХК-ийн Monkondi брэнд болон Алтанговь, Бурамхан зэрэг брэндүүдийг сонгодог.	GRI 204, SDG 8
S6.2		Дотоодын худалдан авалт	Дотоодын ханган нийлүүлэгчдээс авсан худалдан авалтын хувь	100%	100%	%			GRI 204, SDG 8
S6.3		Тогтвортой, ногоон худалдан авалт	Нийт ханган нийлүүлэгчдийн тоонд тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн шалгуургаар сонгогдсон ханган нийлүүлэгчдийн хувь	100%	100%	%	Манай компани үндэсний үйлдвэрлэгчдээ 100% дэмжин ажилладаг. Энэ хүрээнд харилцагчдад өгөх гарын бэлэгтээ "Боса кондитер" ХХК-ийн Monkondi брэнд болон Алтанговь, Бурамхан зэрэг брэндүүдийг сонгодог. Бусад жижиг дунд үйлдвэрлэгчдийн гар урлалын бэлэг сэлтүүд үүнд хамрагддаг.		GRI 204, SDG 8
Засаглалын шалгуур үзүүлэлтүүд									
G1.1	Авлигал болон ёс зүй	Авлигын эсрэг бодлого журам	Авлигын эсрэг эсвэл Ёс зүйн бодлого, журам бий юу?	байсан	1.Тийм		энд дарж үзнэ үү	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 205, SDG 16
G2.1	Компанийн засаглал	Удирдах зөвлөлийн хараат бус байдал	Удирдах зөвлөлд хараат бус гишүүдийн суудлын хувь	60%	33%	%		мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16
G2.2		Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх	Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах дүгэм, журам бий юу?		2.Үгүй			Тухайн дүрэм, журмыг манай компани одоогийн байдлаар баталж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлээгүй байна	GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16
G2.3		Компанийн	Компанийн	байсан	1.Тийм		https://www.tengerdaatgal.mn/investment		GRI 102,

		засаглалын бодлого, журам	засаглалын бодлого, журам бий юу?						OECD Principles of Corporate Governance, SDG 16
G3.1	Комплајнс	Комплаенсын бодлого	Комплаенсын бодлого, журам бий юу?	байсан	1.Тийм		https://www.tengerdaatgal.mn/investment		GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16
G3.2		Комплаенсын хөтөлбөр	Комплаенсын хөтөлбөр, журам (ажилчдын сургалт, аудит, хяналтын систем, зөрчлийн талзэр мэдээлэх, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх удирдамж, хсриг гэх мэт) бий юу?	байсан	1.Тийм		энд дарж үзнэ үү	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16
Нэмэлт салбарын шалгуур үзүүлэлтүүд (Танай компанид хамаарах салбарын асуултуудыг бөглөнө үү)									
FS1	Санхүүгийн үйлчилгээ	Санхүүгийн хүртээмж	Санхүүгийн мэдлэг дээшлүүлэх болон санхүүгийн хэрэглэгчийг хамгаалэх санаачилга, эрга хэмжээнд оролцсон хүмүүсийн тос, жилээр		3,590	хүн	2024 онд тус компани нь "Даатгалын нээлттэй өдөрлөг", "Даатгалын ач тус", "Эрсдэл, даатгалын тухай ойлголт", "Эрсдэлгүй ирээдүй өдөрлөг", "Эрсдэлийн форум" зэрэг үйл ажиллагаагаар болон Дэлхийн санхүүгийн музей иргэдэд санхүүгийн болон даатгалын ойлголтыг өгч ажилладаг бөгөөд 3,590 иргэд хамрагдсан байна. Үүнээс гадна бид харилцагч байгууллагын хөрөнгө, ажлын байрны эрсдэлийг үнэлэн тогтмол сайжруулах зөвлөмж өгч ажилладаг ба энэ талаар сургалт зохион байгуулдаг. Mandal Student төслийн 12 суралцагч нь Дэлхийн санхүүгийн түүхийн музейг монгол, англи хэлээр тайлбарлах чадварт суралцсан. Ингэснээр санхүүгийн музейгээр дамжуулан долоо хоногт дунджаар 20-25 хүнд санхүү, даатгалын боловсрол олгох ажлыг хийж байгаа болно. Иргэдийн эрүүл мэндийн даатгалын боловсролыг дэмжих зорилгоор 2024 оноос эхлэн подкаст хийж эхэлсэн бөгөөд 15 дугаар хийж олон нийтийн хүртээл болгосноор давтагдсан тусгаар 7,500,000 гаруй үзэлт авсан байна.		SDG 1
FS2		БОНЗ-ын эрсдэлийн менежмент	БОНЗ-ын эрсдэлийн шалгуур болон хориотой үйл ажиллагааны жагсаалтаар үнэлсэн гүйлгээний хувь	-	-	%		Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөрийг 2024/2/26-ны өдөр ТУЗ-ийн тогтоолоор шинэчлэн батлуулан ажиллаж байна. Энэхүү хөтөлбөрт хориотой харилцагчийг хэрхэн таних талаар тодорхой дурдсан. Мөн компанийн Алсын хараа, Эрхэм зорилго, Үнэт зүйлсээ тодорхойлж, 2023 онд шинэчлэн баталсан Ёсзүйн дүрэмдээ "Нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгчийн хувьд өгөх амлалт", "Зах зээл буюу даатгуулагчиддаа өгөх амлалт", "Ажилтнууддаа өгөх амлалт", "Хувьцаа эзэмшигчиддээ өгөх амлалт"-уудаа мөн тодорхойлж олон нийтэд нээлттэй байршуулан ажилладаг.	Mongolian Sustainable Finance Principles
FS3		Тогтвортой санхүүжилт	Нийт зээлийн багцад эзлэх ногоон/ТХЗ таксономийн ангилалд нийцсэн ногоон/тогтвортой	-	-	%		НҮБ-ын Уур Амьсгалын Ногоон Сангийн магадлан итгэмжлэгдсэн үндэсний хэрэгжүүлэгч байгууллага болох ХасБанк эрчим хүчний хэмнэлтийн даатгалын механизмыг Тэнгэр даатгал компанитай хамтран Монголд анх удаа нэвтрүүлж, олон	SDG 13, Mongolian Green Taxonomy

			зээлийн зэлзэ хувь					нийтэд танилцуулах арга хэмжээг 2023 онд амжилттай зохион байгуулсан. Эрчим хүчний хэмнэлтийн даатгалын механизм нь зөвхөн даатгалын бүтээгдэхүүн бус санхүүгийн болон бусад механизмыг хослуулан сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх гол хөшүүрэг юм.	
A1	Хөдөө аж ахуй & хүнсний үйлдвэрлэл	Устгалын бодис	Устгалын бодис ашиглах бодлого журам бий юу?		1. Тийм Үгүй			Тус компани нь энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлдэггүй болно.	GRI 403, SDG 12
A2		Тогтвортой газар, бэлчээр	MNS 6891:2020, Хариуцлагатай нүүдэлчин стандарт эсвэл түүнтэй ижил төстэй тогтвортой бэлчээрийн стандартыг хэрэгжүүлж чадсан бэлчээрийн талбайн хувь			%			SDG 12
A3		Буцаан татан авсан бараа бүтээгдэхүүн	Хүнсний чанар, аюулгүй байдлыг хангаагүй буцаагдсан эсвэл худалдах боломжгүй болсон бүтээгдэхүүний хувь			%			GRI 415, SDG 12
T1	Текстиль	Тогтвортой мал аж ахуй	MNS 6891:2020, Хариуцлагатай нүүдэлчин стандарт эсвэл түүнтэй ижил төстэй тогтвортой бэлчээрийн стандартыг нэвтрүүлсэн малын тоо бэлчээрийн зэлзэх хувь			но. & %		Тус компани нь энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлдэггүй болно.	GRI 403, SDG 12
T2		Тогтвортой аргаар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн	Текстилийн тогтвортой үйлдвэрлэлийн стандартын (MNS 6926:2021) дагуу үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо, зэлзэх хувь			но. & %			GRI 416, SDG 12
T3		Химийн бодисын менежмент	Химийн бодис болон хортой материалыг зохистой хадгалах бодлого, журам		1. Тийм Үгүй				GRI 403, SDG 12
MA1	Боловсруулах	Химийн бодисын менежмент	Химийн бодис болон хортой материалыг зохистой хадгалах бодлого, журам		1. Тийм 2. Үгүй		Линк оруулна уу.	Тус компани нь энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлдэггүй болно.	GRI 403, SDG 12
MA2		Дахин боловсруулсан материал	Дахин боловсруулсан материал, орц ашиглалтын хувь			%			SDG 12
MA3		Ногоон шошго, гэрчилгээжүүлсэн байдал	Эко буюу ногоо-шошго, гэрчилгээтэй бүтээгдэхүүний			%			GRI 417, SDG 12

			эзлэх хувь						
MI1	Уул уурхай	Нөхөн сэргээлт	Нийт ашиглалтын зориулалттай газартай харьцуулахад нөхөн сэргээлт хийсэн газрын талбайн хувь			%		Тус компани нь энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлдэггүй болно.	SDG 15
MI2		Торгууль	Байгаль орчны зөвшөөрөл, стандарт, дүрэм журмыг дагаж мөрдөөгүйгээс гарсан зөрчлийн тоо			Зөрчлийн тоо			GRI 307, SDG 15
MI3		Нүүлгэн шилжүүлэлт	Эдийн засгийн шилжилт хөдөлгөөн, нүүлгэлтэд хамрагдсан иргэдийн тоо			Хүн			GRI 203, SDG 1
CO1	Барилга	Ногоон барилгын шошго/ гэрчилгээ	Ногоон барилгын шошго/гэрчилгээ авсан барилгын төслүүдийн хувь			%	Гэрчилгээ авсан төслүүдээ бичнэ үү	Тус компани нь энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлдэггүй болно.	GRI 417, SDG 12
CO2		Хүртээмжтэй байдал	Монгол Улсын хэрэгжиж буй хүртээмжтэй байдлын тухай хууль тогтоомонд нийцсэн барилгын төслүүдийн хувь (үүнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүртээмжийг мөн харгалзан)			%	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээг бичнэ үү.		SDG 10
CO3		Ногоон байгууламж, талбай	Монгол Улсын ногоон байгууламж нийтийн талбайн хууль тогтоомонд нийцсэн барилгын төслүүдийн хувь			%	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээг бичнэ үү.		GRI 304, SDG 15